



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 01 өдөр

Дугаар А/25

Сүхбаатар сум

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.2, Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 39 дүгээр тогтоолын 1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.4, Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.1.8, Сэлэнгэ аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн, 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх болсонтой холбогдуулан боловсролын салбарын ариун цэврийн байгууламжийн дэлгэрэнгүй судалгаа гаргах, тулгамдаж буй асуудал болон ашиглалт, үйлчилгээний асуудлыг шийдвэрлэх, төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, тайлагнах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:

Б.Энхбат

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ч.Жаргалсайхан

Боловсрол, соёл урлагийн газрын дарга

Ажлын хэсгийн гишүүд:

А.Эрдэнэгэрэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Ж.Од

Эрүүл мэндийн газрын дарга

Б.Саруултөгс

Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын дарга

З.Түвшинтөгс

Байгаль орчин, аялал жуулчлалын  
газрын дарга


Д.Баттүвшин

Мэргэжлийн хяналтын газрын дарга

Сумдын Засаг дарга нар

2. Холбогдох мэдээлэл, судалгааг гаргаж, захирамжийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллахыг Ажлын хэсэг /Б.Энхбат/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ